



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 04 сарын 17 өдөр

Дугаар A/35

Улаанбаатар хот

Г Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2017 оны A/167 тоот захирамж, газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Жэй Си Ай" Олон Улсын байгууллагын Ази, Номхон далайн бүсийн чуулга уулзалтыг 2017 оны 06 дугаар сарын 08-11-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Ганболд	Захиргааны хэлтсийн даргын албан ўргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд :	М.Баасандорж	Үйлчилгээний байгууллага, жуулчны аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
	Б.Жаргалан	Хүний нөөц, аялал жуулчлалын байгууллага хариуцсан мэргэжилтэн
	Б.Отгонсувд	Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
	Б.Тулгаа	Хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн
	А.Эрдэнэцогт	Маркетинг, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Ербахыт	Статистик, сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн

2. Нийслэлийн Засаг даргын 2017 оны A/167 тоот захирамжаар хувиарласан үүрэгт ажлыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, явц, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Захиргааны хэлтсийн даргын албан ўргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

ДАРГА *(Signature)* Д.БАТСҮХ



1150500137